

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА ДАХЬ СОРИЛТУУД (ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА)

С.Санасэр*, Ж.Ариунаа**, Ө.Зулбаяр***

Хураангуй: НҮБ-ын гишүүн орнуудаас 2015 онд баталсан тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад улс орнууд ажиллаж эхлээд тодорхой хугацаа өнгөрч байна. Компани болон оролцогч талуудын урьд өмнөхөөс илүүтэйгээр эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчинд нөлөөлж байгаа байдлыг тогтвортой хөгжлийг хангахад ашиглах боломжтой харагдаж байна. Улс орон бүрт компанийн нийгмийн хариуцлагатай холбоотой асуудал янз бүрийн цаг хугацаанд өөр өөр байдлаар хөгжиж ирэхийн зэрэгцээ тулгарч буй асуудал нь ч ялгаатай байна. Бид бусад улс орнуудын компанийн нийгмийн хариуцлагын тэргүүн туршлага дээр тулгуурлан Монгол улсын засгийн газраас ямар чиглэлээр КНХ-ын асуудалд оролцож болох талаар судлахыг зорилоо.

It has been for a while since governments started to work on achieving the sustainable development goals (SDG), adopted by all United Nations Member States in 2015. Companies and their stakeholders have ever had an impact on the economy, society and the environment. This shows, on the other hand, that they can be used for sustainable development. In different countries, however, the issue of corporate social responsibility has evolved in different ways, and even today it is also facing many different challenges. The study aims to determine the extent to which how the Government of Mongolia can participate in corporate social responsibility (CSR) issues based on the best practices in different countries.

Түлхүүр үгс: Corporate social responsibility, sustainable development goal

¹ МУИС-ийн Бизнесийн сургууль, (e-mail) ssanaser@gmail.com

² МУИС-ийн Бизнесийн сургууль, (e-mail) j.ariunaa2012@gmail.com

³ МУИС-ийн Бизнесийн сургууль, (e-mail) zulbayar.ulziibayar@gmail.com

Судалгааны ач холбогдол

Даяаршиж буй дэлхий ертөнцөд компаниуд улам бүр ижил стандарт, тодорхой нэгдсэн чиглэлээр хөгжих хандлагатай байна. Ялангуяа тогтвортой үйл ажиллагаатай компаниуд нийгмийн сайн сайхан байдалд чиглэсэн үүрэг гүйцэтгэх төлөвтэй болж байна. Компаниуд баялаг бүтээхээс өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах талаар хөгжингүй орнуудад яригдаж эхлээд багагүй хугацаа өнгөрлөө. Ази, Европ, Америк тивийн орнуудын компанийн нийгмийн хариуцлагын талаар баримталж байгаа бодлогыг судалснаар өөрийн орны онцлогт тохирсон компанийн нийгмийн хариуцлагын бодлогыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Мөн түүнчлэн КНХ-ыг дээшлүүлэх, тогтвортой хөгжлийг хангахад төрийн зөв зохицуулалт, төр хувийн хэвшлийн үр нөлөөтэй түншлэлийн механизм, тогтолцоог бий болгох арга замыг тодорхойлоход практик ач холбогдол оршино.

Судалгааны арга зүй

Судалгааны хамрах хүрээ: Ази болон Европын улсууд тухайлбал Япон, БНСУ, БНХАУ болон ХБНГУ-ын компанийн нийгмийн хариуцлагын бодлого, зохицуулалт, дүрэм, журам

Судалгааны объект: Сонгосон орнуудын КНХ дахь оролцогч талууд

Судалгааны арга:

- 1) Судалгааны хамрах хүрээний улсуудын КНХ-ын талаарх эрдэм шинжилгээний ажлуудад дүн шинжилгээ хийх, нэгтгэх
- 2) Олон улсын стандарт, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх
- 3) Улс орнуудын төрөөс баримтлах нийгмийн хариуцлагын бодлого, авч хэрэгжүүлж байгаа стандартыг харьцуулах

Удиртгал

Үйл ажиллагаа нь тогтворжсон, харьцангуй ашигтай ажиллаж байгаа компаниуд хүн амын аж байдлыг тэтгэж, хүрээлэн буй орчин болон нийгэмд чухал үүрэг гүйцэтгэх хандлага олон улс оронд ажиглагдаж байна. Компаниуд зөвхөн хувьцаа эзэмшигчдийнхээ ашгийг нэмэгдүүлэх, улсад татвар төлөх, хүмүүсийг ажиллуулахаас өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах тухай асуудал яригдаж эхлээд тодорхой хугацаа өнгөрчээ.

КНХ гэдэгт ашгийг хамгийн их байлгах гэсэн суурь зарчим дээр нийгэм болон хүрээлэн буй орчны асуудлыг давхар авч үздэг олон улсын ойлголтыг

хамааруулдаг (Elkington, 1994; Dyllick ба Hockerts, 2002; Dahlsrud, 2008).

Зарим компаниуд санхүүгийн хувьд ашигтай ажиллаж байгаа боловч тэнд ажиллаж байгаа ажилчид, мөн хэрэглэгчид, оршин суугчид, хүрээлэн буй орчны өмнө сөрөг нөлөө үзүүлдэг. Үүнийг оролцогч талууд, нийгмийн түншүүдтэй хамтран өөрчлөхөд төрийн шийдэл гол үүргийг гүйцэтгэдэг учир төр ба хувийн хэвшлийн түншлэлийн асуудал даяаршиж байгаа дэлхий ертөнцөд хүчтэй яригдаж байна.

Эдийн засаг, нийгэм болон хүрээлэн буй орчны оролцогч талуудын хамтын ажиллагааг хамгийн сайн байлгах замаар бизнесүүд нь дэлхий ертөнцийн түгээмэл эрхэм зорилго болох тогтвортой хөгжил рүү сайн дураараа оролцох асуудал хүлээгдэж байна. Тогтвортой хөгжил гэдгийг ирээдүй үеийнхний хэрэгцээг бууруулахгүйгээр өнөө үеийнхэний хэрэгцээг хангах (WCED 1987; КНХ ба тогтвортой хөгжлийн харилцан хамаарал, Steurer, 2005 ба Moon, 2007) гэж тодорхойлсон байдаг.

Хэдийгээр КНХ-ын түгээмэл суурь ойлголт (Donaldson ба Preston, 1995) байдаг ч тодорхой цаг хугацаанд болон бүс нутгуудад тайлбар болон үйл ажиллагаа нь өөрчлөгдсөөр иржээ. Энэ нь АНУ, Европ, Ази тив хоорондын ялгаанаас гадна Баруун Европ, Төв Европ, Зүүн Европ, тэр байтугай тухайн бүс дэх улсууд хооронд хүртэл ялгаа байгааг судалгаанууд харуулж байна (Aarons, 2002; Midttun 2006; Welford, 2004). Тухайлбал НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн КНХ-ын судалгаагаар (2007) “Бизнес болон олон нийтийн байгууллагуудад социализмаас үлдсэн ерөнхий ойлголт байдаг нь нийгмийн хариуцлага болон нийгмийн халамж гэдэг бол засгийн газрын үндсэн ажил, ихэнхи компаниуд өөрсдийн үүрэг хариуцлагыг тухайн улсын хуулийн хүрээнд ажиллах гэдэг байдлаар авч үздэг” гэж дүгнэсэн байдаг.

Clarkson болон Mitchell (1998) нарын судалгаагаар дэлхийн бүс нутгуудад КНХ ялгаатай байгааг компани болон байгууллагын оролцогч талуудын хүлээлт, шаардлага нь өөр өөр байдагтай холбож тайлбарласан байдаг. Цаашилбал соёлын ялгаатай байдал нь компанийн талаарх ойлголтонд өөр өөрөөр тусаж энэ нь КНХ-ын бодлогод тусгалаа олсон талаар Steurer, Konrad (2009) нар болон Moon (2009) нарын судалгаа харуулсан.

“Компанийн нийгмийн хариуцлагын ёс зүйн асуудал нь хүнийг хүн гэж хүлээн зөвшөөрөгдөх, хүндлэгдэх эрхээс урган гарч байгаа юм. Компанийн ашиг бол эцсийн зорилго биш бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаанд хүн, байгаль орчин, нийгмийн бусад асуудлыг анхаарлын төвд тавьсан ёс зүйн суурийг бий болгох хэрэгтэй”⁴

КНХ нь нийгмийн шаардлага, хүсэл эрмэлзлэлд үзүүлж буй хариу үйлдэл

⁴ Дэлхийн эдийн засаг дахь компанийн нийгмийн хариуцлага. Норвегийн парламентад хэлэлцүүлэх тайлан №10 (2008-2009)

гэж үзвэл энэ нь зөвхөн хуулийн хүрээнд ажиллахаас давсан ойлголт болж байна. Иймд КНХ нь сайн дурын ажлыг өөртөө агуулдаг, учир нь нийгмийн бүхий л асуудлыг хуулиар зохицуулах боломжгүй.

Энэ бүхнээс харахад КНХ-ын асуудлууд нь компаниуд болон засгийн газар зэрэг оролцогч талуудаас хамааралтай байдаг. Тухайлбал засгийн газар зөвхөн хуулинд тусгах агуулга дээр ажиллахаас гадна КНХ-ын цаад мөн чанарыг таниулах, улмаар албадагын бус арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлэн удирдаж манлайлахын чухлыг Albareda болон Steurer (2006;2010) нарын судалгаанд тусгасан байдаг.

ЕВРОПЫН ХОЛБООНЫ ОРНУУДЫН КНХ ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО БА АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО ЗАРЧИМ

Европ дахь КНХ-ын бодлогын бүс нутгууд дахь ялгаатай байдлыг хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Европ дахь нийгэм-эдийн засгийн (five socio-economic model) загварын ерөнхий тойм⁵

Загвар	Европын холбооны улсууд	Үзэл баримтлалын хандлага	Төрийн нийгмийн халамжийн талаарх онцлог
Скандиновын	Швед, Финлянд, Дани, (Нидерланд)	Социал демократ	<ul style="list-style-type: none"> Бүх иргэдийнхээ нийгмийн эрх (хүний эрх, боловсрол эзэмших, байр оронтой байх, эрүүл амьдрах, ШУ соёлыг таньж мэдэх зэрэг эрх)-ийг хангахыг зорих Нийгмийн өндөр стандартыг бүх иргэддээ тэгш хангахыг дэмжих Нийгмийн халамжийг нийгэмд эзлэх байр суурь, нийгмийн анги давхаргаас үл хамааруулан бүх нийтэд тэгш хүртээх бодлого
Эх газрын	Герман, Австри, (Франц, Белги, Люксембург)	Консерватив	<ul style="list-style-type: none"> Хөдөлмөр эрхэлдэг эхчүүдийг хүчтэй дэмжих Нийгмийн анги давхарга болон нийгэмд эзлэх байр суурийн ялгаанд тулгуурлан нийгмийн халамжийг олгох (эрхэлж байгаа ажил, нийгмийн даатгалаас хүртэж байгаа хөнгөлөлт зэргийг харгалзах) Дахин хуваарилалт хязгаарлагдмал Нийгмийн бодлого нь уламжлалт гэр бүлийн бүтцийг хадгалах зорилготой (үүний тулд эмэгтэйчүүдийн эрх чөлөөг тодорхой хэмжээнд хязгаарлах)

⁵ The three worlds of welfare capitalism, Esping Anderson (1990), Pierson, 1998; Aiginger and Guger, 2005

Англи - Саксоны	Англи, (Ирланд)	Либерал	<ul style="list-style-type: none"> Зах зээлийн харилцаанд илүү суурилсан захиран зарцуулах бодлоготой (хувийн хэвшлээс нийгэмд үзүүлэх халамж үйлчилгээг төрөөс дэмждэг) Нийгмийн халамж нь маш энгийн, халамж авах шаардлагатай эсэхийг нягталдаг буюу авах ёстой хүмүүст л халамжийн бодлогыг хэрэгжүүлдэг.
Газар дундын тэнгисийн	Испани, Португал, Грек, (Итали)	Холимог	<ul style="list-style-type: none"> Харьцангуй цөөн, тодорхой хэсэг хүмүүсийн орлогын баталгаат /тэтгэвэр/ байдлыг анхаарч түүнийг баталгаат түвшинд байлгах бодлого барьдаг. Нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай хэсэг буюу гэр бүл, сүм хийдэд анхаарал тавьдаг уламжлалт хандлагаа сайжруулан хөгжүүлж байгаа
Шилжилтийн	Төв, зүүн европоос Европын холбоонд шинээр элссэн орнууд	Хөгжиж буй	<ul style="list-style-type: none"> Нийгмийн халамжийн шинэ бодлогыг хөгжүүлж байгаа ч маш олон асуудалтай тулгарч байгаа. Нийгмийн хэрэглээ зарцуулалт нь EU-15¹ дунджаас доогуур байгаа Ядуурлын түвшин нэмэгдэж байгаа

Европын орнуудад засгийн газар нь КНХ-даа ямар бодлого зарчим баримталдаг талаар Steurer (2010) судалгаандаа дараах таван бодлогын арга хэрэгслийг ялган авч үзсэн. Үүнд: Хууль, Эдийн засаг, Мэдээлэл, Түншлэл, Холимог хэрэгсүүд.

Мөн бодлого хэрэгжүүлэх дөрвөн зарчмыг мөн ялган авч үзсэн. Үүнд: КНХ-ыг таниулах, нээлттэй байдал, нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт болон бодит жишээгээр манлайлах

Бодлогын арга хэрэгслүүд:

- Хуулийн арга хэрэгсэл — Төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд тусгах шаардлагатай асуудлуудыг зааж өгдөг. Үүнд ихэнхдээ шатлан захирах ёс, эрх мэдэлтэй холбоотой асуудлууд ордог. КНХ-ыг компаниудад заавал тулгах гэхээс илүүтэй санал болгох байдлыг тусгасан байдаг.
- Эдийн засгийн арга хэрэгсэл — Санхүүгийн хөшүүрэг, татвартай холбоотой бодлогын хэрэгслүүдийг авч үздэг. Гол зарчим нь санхүүгийн болон зах зээлийн хөшүүргүүдийг ашиглан нөлөөлөх юм. Судалгаагаар хамгийн үр дүн багатай нь татаас болон төрийн шагнал урамшуулал болж байна.
- Мэдээллийн арга хэрэгсэл — Энэ нь өнөөдрийг хүртэл бий болсон

мэдлэг, мэдээлэл дээр тулгуурладаг. Ёс суртахууны болон баримт нотолгоонд тулгуурласан мэдлэг, мэдээлэл агуулагддаг. Тухайлбал засгийн газрын дэмжлэгтэй КНХ-ын мэдээлэл түгээх, ойлгуулах аян, сургалт вэб сайт гэх мэт.

- Түншлэлийн арга хэрэгсэл – Засгийн газрын алба хэлтсүүд болон бизнесүүд хамтдаа хоршиж хийх ажлууд үүнд хамаардаг. Бие биенийгээ нөхөх, өөрсдийн нөөц боломжуудыг солилцох, мөн хатуу дүрэм журамд баригдахаас хол байх гэсэн зарчмуудыг чухалчилдаг.
- Холимог арга хэрэгсэл – Дээр дурдагдсан арга хэрэгслүүдээс хоёр болон түүнээс олон арга хэрэгсэл хоршиж хэрэглэгдэх зарчим юм. Дээрхи арга хэрэгслүүд нь засгийн газрын явуулж буй хүрээлэн буй орчин болон нийгмийн хүрээний заавал мөрдөх ёстой хатуу дүрэм журмуудад нэмэр болдог талаар энэ судалгаанд онцгойлон дүгнэсэн байна.

Бодлого хэрэгжүүлэх зарчмууд:

- КНХ-ын танин мэдэхүйг нэмэгдүүлэх, чадавхийг бий болгож үр дүнд хүргэх - Компани болон оролцогч талууд нийгмийн ба хүрээлэн буй орчны асуудлуудыг яаж ойлгохоос гүйцэтгэл хамаардаг болохыг энд онцолдог.
- Тайлагнал болон нээлттэй байдлыг нэмэгдүүлэх - Компанийн нийгмийн хариуцлагыг чухалчилдаг оролцогч талууд болох хөрөнгө оруулагчид, бодлого тодорхойлогчид, ажилчид болон хэрэглэгчдэд шаардлагатай эдийн засаг, нийгэм хүрээлэн буй орчны мэдээлэл нь нэн тэргүүний чухал зүйл юм. Засгийн газар нь байгууллагуудын КНХ-ын тайлагналд онцгой үүрэг гүйцэтгэх ёстойг энэ судалгаанд тусгасан.
- Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт (SRI) - Эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин болон бусад ёс зүйн шалгуур үзүүлэлтийг хөрөнгө оруулалтын шийдвэрт авч үзсэнээр оролцогч талуудын сонирхлыг хувьцаа эзэмшигчид, өмчийн эзэдтэй нийлүүлдэг.
- Засгийн газар үлгэр жишээгээр манлайлах болон урамшуулах - Засгийн газар өөрийн харьяаны байгууллагуудаас эхлээд түүнтэй холбоотой орчинд КНХ-ын зарчмуудыг бүх түвшинд бодолцож ажиллах. Ялангуяа засгийн газрын худалдан авалтанд эдгээр шалгуурыг баримтлах нь ач холбогдол өндөртэй байдаг.

Steurer (2010) судалгаандаа дээрхи таван аргыг дөрвөн зарчимтай хослуулсан матрикс боловсруулсан нь КНХ-ын бодлого боловсруулахад ач холбогдолтой болсон.

АЗИЙН ОРНУУДЫН КНХ ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО БА АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО ЗАРЧИМ

Европ болон АНУ-тай харьцуулахад Азийн ихэнхи улсуудын КНХ-ын талаар баримталж буй бодлого, туршлага, зарчим нь нэлээн хожуу танилцуулагдсан байдаг. Японы зарим судалгаануудыг (Fukukawa, Moon 2004; Lewin, Sakano, Stephens, Victor 1995) эс тооцвол БНСУ зэрэг хурдацтай хөгжиж буй улсуудад КНХ-ын талаарх судалгаа 2005 оныг хүртэл ховор байна. БНСУ-ын хувьд тухайн үед цөөн тооны (Chapple & Moon 2005; Welford 2005 гэх мэт) харьцуулсан судалгаанууд хийгдсэн байдаг.

БНСУ ба Япон

1500 орчим жил соёл болон нийгмийн үнэт зүйлээ солилцож байсан Япон, Солонгос хоёр улсын хувьд буддизм, күнз дээр тулгуурлаж ирсэнээрээ төсөөтэй.

Японы КНХ-ын талаар Wokutch (1990) тайлбарлахдаа соёлын түлхүүр хүчин зүйлс болох үүрэг, хариуцлагын мэдрэмж болон баг бүлгийн гишүүнчлэлийн ач холбогдлыг күнзийн философид тулгуурлан тайлбарласан байдаг. XIX зуунаас Японы институцын хууль Германы хуулиас эх авсан. Энэ нь 1910-1945 онд Солонгосын арилжааны хуулийн суурьд нөлөө үзүүлсэн (Hamilton ба Biggart, 1988).

Харьцангуй сүүлийн судалгаануудад шат шатны менежерүүдийн хандлага болон үнэт зүйлд тулгуурлан үнэлгээ хийсэн байдаг. (Maignan & Ferrell, 2003; Quazi & O'Brien, 2000 гэх мэт) Энэ судалгаагаар ажилчдын хувь хүний үнэт зүйл, КНХ-ын талаархи ойлголт нь хариуцлагатай компанитай шууд хамааралтай гэж үздэг.

БНХАУ

БНХАУ-ын төрийн оролцоотой компаниудын үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагын бодлого нь барууны орнуудынхаас онцлогтой. Энэ нь компанийн засаглал, төрийн өмчлөлтэй холбоотой байж болох юм. Тухайлбал Алдо (2015) нарын судалгаагаар Хятадын засгийн газар төрийн өмчит компанийн засаглалыг гурван арга замаар өөрчилж чадсан.

1. Нийт эсвэл дийлэнх хувьцааг төр эзэмшдэг төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд компанийг бүртгэх, хараат бус удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, санхүүгийн тайлагналыг сайжруулах замаар компанийн засаглалын үйл ажиллагааг сайжруулдаг. Төрийн өмчит томоохон компаниудын хувьд эдгээр шинэтгэл нь дотоод зөрчилдөөнийг багасгаж, хувийн хөрөнгө оруулагчдыг татдаг (Gupta, 2005; Pargendler, Musacchio, & Lazzarini, 2013). Жишээ нь Хятадын

газрын тосны үндэсний компаниудын нэг Sinopec нь төрийн өмчийн ашигтай ажилладаг компаниудын жишээ бөгөөд орлого, хөрөнгөөрөө дэлхийн тэргүүлэх компаниудын тоонд ордог.

2. Төр өөрийн бүрэн мэдэлд байгаа компанийхаа зарим хувьцааг тодорхой тооны хуулийн этгээдүүдэд олгож өөрийн үйл ажиллагаандаа хувийн хэвшлийг оруулсан байдаг. (Inoue, Lazzarini, & Musacchio, 2013) Ингэснээр засгийн газрын зардал болон мөнгөн гүйлгээний менежментийг хувийн хэвшилд захиран зарцуулах эрхийг олгон, олон тооны алтан хувьцаагаар дамжуулан нэгдэх, нийлэх зэрэг стратегийн гол шийдвэрүүдийг гаргах эрхийг олгодог. Жишээ нь, 2014 оны 1-р сард Францын хувийн автомашины Peugeot компани Хятадын төрийн өмчит Dongfeng компанигаар өмчөөрөө хамтран аж ахуй эрхлэх гэрээ байгуулсан.
3. Засгийн газар нь тодорхой салбар, аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн бодлогыг барьснаар томоохон стратеги боловсруулдаг оролцогч тал болдог (Amsden, 2001; Mazzucato, 2011).

Компанийн засаглал, төрийн оролцооны ялгаатай байдлаас хамаараад компанийн нийгэм рүү чиглэсэн ажлууд өөр өөрийн онцлогтой байна. Тухайлбал засгийн газраас нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ төрийн өмчийн оролцоотой компаниудыг шууд ашигладаг ба энэ нь тухайн компаниудын ашигт ажиллагааг бууруулдаг. Гэсэн хэдий ч засгийн газар энэ зарчмыг баримталдаг. Жишээ нь засгийн газраас төрийн өмчит компанийг бага орлоготой иргэдэд үйлчлэх, үнийг хямд байлгах, ажилгүйдлийг багасгах, газар зүйн алслагдсан бүс нутагт хөрөнгө оруулах зэргээр ажиллуулдаг (Bai & Xu, 2005; Shirley & Nellis, 1991). Төрийн үйлчилгээ нь ашиг нэмэгдүүлэх, зардал хэмнэх, нөөцийн хэт их зарцуулалт зэрэгт анхаарал хандуулдаггүй. Зарим төслүүд нь зөвхөн урт хугацаанд үр дүнд хүрэх боломжтой тул хөрөнгө оруулагчид, менежерүүд хөгжлийн зорилгодоо тууштай байхыг шаарддаг. Энэ утгаараа Төрийн өмчит компаниуд ашигт ажиллагаанд анхаардаггүй, нийгмийн тодорхой зорилтууддаа хүрэхийг л чухалчилдаг. (Bai & Xu, 2005). Дүгнэж хэлэхэд, Хятадын төрийн өмчит компанийн цэвэр ашиг сөрөг байж болох хэдий ч олон нийтэд үзүүлж буй үр ашиг нь эерэг байдаг.

Хятадын төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалын хандлагыг хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Хятадын төрийн өмчийн хэлбэр

	Төрийн өмчит компани	Төрийн хөрөнгө оруулалт давамгайлсан компани	Төрийн хөрөнгө оруулалт багатай компани	Төрийн стратегийн оролцоо
Удирдлагын алба	Захиргааны алба нь төрийн өмчит компанид удирдлагын практикийг сайжруулах (ашиггүй хөрөнгө оруулалт, дотоод хяналтгүй байдал, хангалтгүй гүйцэтгэл)	Захиргааны албаны асуудал нь чиглүүлэг болдог. Гүйцэтгэгчийн үнэлгээгээр цалинждаг.	Захиргааны албан чиглүүлэг муу	Засгийн газраас мэргэжлийн менежерүүд ажиллуулдаг хувийн компаниудыг дэмждэг.
Нийгмийн үзэл баримтлал	Удирдлага 2 үндсэн асуудалтай нүүр тулгардаг. Харилцан бага үнэ, өндөр ашиг. Ашиг болон үр бүтээмжийн тохирох хослолыг бүтээнэ.	Дотоод хариуцлагыг ашигтай холбогдуулан нэмэгдүүлэх, албаны гүйцэтгэлийн нөлөө төрийн өмчит компаниас тусгаарлан сайжруулах	Ашгийг онцолдог. Хөндлөнгөөс оролцох чадвар зөрүүтэй байх зэргээс бусад тохиолдолд	Бодлогын зорилгод тулгуурлан ашигт ажиллагаанд онцгой анхаарал хандуулах
Улс төрийн үзэл бодол	Төрийн өмчит компани ашиг дотроо улс төрийн өгөөжийг оруулдаг. Удирдлагыг төрөөс чиглүүлэх ба ашиг нь төртэй холбогддог.	Удирдлагыг авах нь бараг дампууралд хүргэдэг. Гэсэн хэдий ч удирдлагын чадавхийг сайжруулсан нь улс төрийн хамтарсан дэмжлэг SOE ашиглахад илүү хэцүү болдог.	Үндсэн төсвийг хязгаарладаг. Хэрвээ үндэсний хэмжээнд эсвэл улс төртэй эрчимтэй холбогдсон бол хязгаарлалт нь бага байдаг.	
Байгууллагад суурилсан үзэл баримтлал	Байгууллагын орчин нь загвар бүрийн гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйл болдог.			

Төрийн өмчит компани

Энэ нь засгийн газрын өмчлөлийн уламжлалт хэлбэр юм. XIX зуунаас эхлэн засгийн газар шуудан, ус, цахилгаан, төмөр зам гэх мэт олон нийтийн эд зүйлсийг удирдахын тулд төрийн өмчит компаниудын тоо нэмэгдсэн. (Millward, 2005, Toninelli, 2000). Эдгээр төрийн өмчит компаниуд нь засгийн газраас шууд санхүүжилт авдаг бөгөөд улс төрөөс хамааралтай байдаг нь ил тод, бие даасан, хариуцлагатай байдлыг хязгаарлагдмал болгодог.

Төрийн хөрөнгө оруулалт давамгайлсан компани

Төр нь хяналтын багц эзэмшигч байх боловч хувийн хөрөнгө оруулагчдыг татах бодлого барьдаг. Жишээ нь, дэлхийн хамгийн том газрын тосны компаниудын тал хувь нь өөрийн улс оронд, Нью Йоркийн Хөрөнгийн Бирж дээр, эсвэл хоёулан дээр нь нийтэд мэдээлдэг бөгөөд тэд хувийн компанитай төстэй засаглалын хэлбэрийг баримталдаг (Масакчио & Лазарарини, 2014).

Ардчилсан бус улсуудад засгийн газар нь ихэнх хувийг эзэмшдэг компаниуд олон байдаг бөгөөд тэдгээрийг бусад төрийн өмчит болон хувийн компанитай харьцуулахад ихээхэн ялгаатай. Жишээ нь, газрын тосны Газпром, Оросын Роснефть, Бразилын Петробас, Синопек, БНХАУ-ын CNOCC гэх мэт.

Төрийн хөрөнгө оруулалт багатай компани

Энэ нь төр бага хувийг, хувийн хэвшил ихэнхи хувийг эзэмшдэг өмчлөлийн хэлбэр бөгөөд менежментийн хяналт нь хувийн гарт байх учраас удирдах албан тушаалтан, нийгэм, улс төрийн асуудлууд бага нөлөөлдөг. Төрөөс санхүүжилтгүй үлдсэн эсвэл эрсдэлтэй, урт хугацааны хувийн төслүүдийг санхүүжүүлэх боломжтой. Өөрөөр хэлбэл энэхүү загвар нь хөрөнгийн зах зээл дэх институтын хоосон зайг бий болгосноор компанийн түвшинд далд зохицуулалтыг идэвхжүүлж чадна.

Энэ бүх давуу талыг үл харгалзан зарим үед төрөөс тодорхой нөхцөл байдалд хөндлөнгөөс буюу эзэмшиж буй хувьцаагаараа дамжуулан үйл ажиллагааг хянадаг, шууд оролцоод байдаггүй. Төр ихэнх хувьцааг нь эсвэл дангаараа эзэмшдэг компанитай харьцуулахад төсвийн хувьд хязгаарлагдмал байдаг. Төрөөс бага хувьцаа эзэмших нь төрөөс ихэнх хувьцааг эзэмшдэг төрийн өмчлөлийн компаниас чанарын хувьд ялгаатай.

Төрийн стратегийн оролцоо

Төрийн стратегийн оролцооны энэхүү загварт төр нь хувийн аж ахуйн хөдөлгүүр болж ажилладаг. Стратегийн оролцоо нь хөгжлийн болон төрийн өмчит банкуудаар дамжуулан гол төлөв цөөнхийн өмч хэлбэртэй байж болно. Энэ загвар нь шинэ компаниудын чадавхийг нэмэгдүүлэхийн тулд аж

үйлдвэржсэн салбарыг бий болгох явдал юм. Энэ нь олон салбарыг хамарсан “хэвтээ” бодлогуудын хослол (жишээ нь, суурь боловсрол ба шинжлэх ухааны хөрөнгө оруулалт) шинэ үйл ажиллагаануудыг төрөлжүүлэхэд чиглэсэн “босоо” бодлоготой хослуулахыг дэмждэг хувийн бүлгүүдээс бүрддэг.

Байгууллагад суурилсан үзэл баримтлалын дагуу, Aghion (2011) бодлогын хүрээнд шинэчлэгдэх төслүүдэд зардлыг багасгаж, нууцлалын чадамжийг шинэчилдэг тогтолцоог санал болгосон. Төр нь хоосон зайг шууд (жишээ нь, шинэ R&D үйл ажиллагааны татварын хөнгөлөлт) эсвэл их дээд сургуулиуд, мэргэжлийн эрдэм шинжилгээний төвүүд зэрэг улс, үйлдвэрлэлийн түвшний нөөцөөр хангах замаар шууд бусаар (Lazzarini, 2013) нөхөж болно. Үүний зэрэгцээ төрөөс аж ахуй эрхлэгчдийг нийгмийн өндөр ач холбогдолтой, эрсдэлтэй төсөл хэрэгжүүлэхийг уриалж байгаа бол харин бизнес эрхлэгчид голчлон төрийн бодлогыг хэрэгжүүлэх, урамшуулал бий болохыг хайж байдаг.

Дүгнэлт

- Өндөр хөгжилтэй орны үндэстэн дамнасан компаниуд зөвхөн өөрийн оронд бус, үйл ажиллагаа явуулж буй тухайн улсад шаардлагатай компанийн нийгмийн хариуцлагын асуудлуудад манлайлах, үлгэр жишээ үзүүлэн ажиллах хандлагууд бий болж байна. Энэ нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, авилгын түвшин өндөр орнуудад ёс зүйн манлайлал үлгэрлэл үзүүлэх зорилго тавин ажиллаж байгаа барууны орнуудын жишээнээс харагдаж байна.
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн КНХ-ын судалгаагаар “Бизнес болон олон нийтийн байгууллагуудад социализмаас үлдсэн ерөнхий ойголт байдаг нь нийгмийн хариуцлага болон нийгмийн халамжийг засгийн газрын үндсэн ажил” гэж дүгнэсэн байдаг. Энэ нь барууны орнуудаас үнэт зүйлийн хувьд эрс ялгаатай манай улсын хувьд мөн тийм байх магадлалтай байгаа нь олон улсын түгээмэл ойлголтоос өөр байгаа бөгөөд ойлголтын зөрүүг өөрчлөх шаардлагатайг харуулж байна. Монгол улсад КНХ-ыг хүн, нийгэм, хүрээлэн буй орчин гэсэн гурван үндсэн агуулгаар бүгд ижил ойлгодог байдлаар тодорхойлж өгөх шаардлагатай байна.
- Компанийн нийгмийн хариуцлага нь тивээс тив, улсаас улс, салбараас салбар, корпорациас корпораци дамжин агуулгын хувьд ойролцоо байгаа боловч үзэл баримтлалд ялгаа харагдаж байна. Засгийн газар КНХ-ын бодлогыг тодорхойлохдоо тухайн улс орнуудын оролцогч талуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэт зүйл, үзэл баримтлалтай холбогдуулах замаар хэрэгжүүлэхэд үр дүнд хүрэх боломжтой байна.

Засгийн газар, иргэд, тухайн компанийн ажилчдын хувь хүний үнэт зүйл, нийгэм хүрээлэн буй орчны хариуцлагын талаарх чин хүсэл эрмэлзлэл нь тухайн компанийг хариуцлагатай болгож төлөвшүүлдэг.

- Европын орнуудад хийсэн судалгаагаар КНХ-ыг дэмжих хамгийн үр дүн багатай аргад татаас болон төрийн урамшуулал орж байна. Засгийн газраас төр өөрийн өмчит компанийн засаглалаар дамжуулан КНХ-ыг хэрэгжүүлэх, манлайлах, бусад хувийн хэвшилд эерэгээр нөлөөлөх боломж байна.
- КНХ-ын хүрээнд ихэнхидээ компаниудад засгийн газар заавал тулгах байдлаар асуудалд хандахаас илүүтэй санал болгох зарчмаар бодлого боловсруулах нь илүү үр дүнтэй байна.
- Европын орнуудад хэрэглэгдэж буй КНХ-ын таван бодлогын арга хэрэгслийг цогцоор нь авч үзвэл үр дүн сайтай байх боломжтой. Үүнд: Хууль, эдийн засаг, мэдээлэл, түншлэл болон холимог хэрэгсүүд. Ингэхдээ КНХ-ыг хэрэгжүүлэх дөрвөн зарчим болох КНХ-ыг таниулах, нээлттэй байдал, нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт болон бодит жишээгээр манлайлах зэргийг хамтад нь авч үзэх шаардлагатай байна.

Ашигласан материал

- [1] Дэлхийн эдийн засаг дахь компанийн нийгмийн хариуцлага. Норвегийн парламентад хэлэлцүүлэх тайлан №10 (2008-2009)
- [2] Seungho Choi, Ruth V.Aguilera. 2007. Corporate social responsibility dynamics in South Korea and Japan: A comparative Analysis
- [3] Reinhard Steurer, Andre Martinuzzi, and Sharon Margula, “Public Policies on CSR in Europe: Themes, Instruments, and Regional Differences,” *Corporate Social Responsibility and Environmental Management*, 2012.
- [4] Ramon Mullerat, “International Corporate Social Responsibility. The Role of Corporations in the Economic Order of the 21st century”, 2010
- [5] Ramon Mullerat, “European Commission’s CSR. National Public policies in the European Union, 2010.
- [6] OECD (2011), OECD Guidelines for Multinational Enterprises, OECD Publishing
- [7] Aldo Musacchio, Sergio G.Lazzarini, Ruth V.Aguilera, “New varieties of state capitalism: Strategic and governance implications”, the academy of management perspective 2015, Vol.29, No. 1, 115-131
- [8] <https://epi.envirocenter.yale.edu/downloads/epi2018policymakerssummaryv01.pdf>

- [9] http://aei.pitt.edu/43368/1/Mullerat_CSR_Europa.pdf
- [10] <https://www.csr-in-deutschland.de/EN/Policies/CSR-national/CSR-Policies-in-Germany/csr-policies-in-germany-article.html>